Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр: Биднийг нэгтгэж буй ардчиллын үнэт зүйлсийг дахин баталгаажуулах боломж

Нээлттэй захидал. Хэргийг түр хамаарагч Брайн Голдбек
2008 оны Тавдугаар сарын 2

АНУ-ын Төрийн Департаментаас саяхан гаргасан 2007 оны Хүний эрхийн тайландаа дараах язгуур үнэн зүйлд дэлхий нийтийн анхаарлыг хандуулсан билээ: "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, энх тайвнаар хуран чуулах эрх чөлөө нь иргэний нийгэм, хараат бус хэвлэл мэдээллийн хувьд хүчилтөрөгч мэт чухал юм. Эдгээр үндсэн эрх чөлөөгүйгээр ардчилал амьсгалах аргагүй болно гэсэн үг. Харамсалтай нь 2007 онд дэлхийн бүх бүс нутгийн орнуудын засгийн газар ТББ-ууд, сэтгүүлчид болон бусад иргэний нийгмийн идэвхтнүүдийн эсрэг өөрсдийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглаж хуулийг гажуудуулсан байна."

Дэлхийн олон нийт, ардчилал, энх тайвныг олон улсын хэмжээнд хөхүүлэн дэмжигч түншүүдийн хувьд Америкчууд болон Монголчууд та бид Тавдугаар сарын 3 буюу Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг аливаа факт баримтыг бодитоор мэдээлэхийн төлөө мөн түүнчлэн чөлөөт хэвлэл, үзэл бодлын эрх чөлөө, ардчиллын өмнө хүлээсэн үүргээ дахин батлахын тулд амь насаа зоригтойгоор золиосолсон дэлхийн болон Монголын сэтгүүлчдийн дурсгалыг хүндэтгэх таатай завшаан хэмээн ойлгож тэмдэглэх учиртай.

Хэвлэлийн эрх чөлөө нь Америкийн түүх, Америкийн ардчиллын үндсэн суурь нь юм. Америкийн тусгаар тогтнолын удирдагчид колончлолын тогтолцооны шударга бус үйлдлүүдийг хэвлэлээр дамжуулан ил гарган тавьж байсан ба АНУ-ын Үндсэн хуульд анхны нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахдаа шашин шүтэх, хэвлэн нийтлэх, үг хэлэх, энх тайвнаар хуран чуулах эрх чөлөөг төдийгүй засгийн газарт өргөх бичиг хүргүүлэх эрх чөлөөг баталгаажуулж өгсөн.

Аливаа ардчилсан нийгэмд хэвлэл нь олон нийтэд мэдээлэл хүргэх, тэдний боловсролд туслах үүрэг хүлээдэг. Олон нийтийн бодлогын талаар ухаалаг шийдвэр гаргахад оновчтой, цаг үеэ олсон, тэнцвэртэй мэдээлэл хүмүүст шаардлагатай байдаг. Хэвлэл мэдээллийн өөр нэгэн үүрэг нь аливаа бодлого, ажлыг өөрсдийн үзэл бодол мэт онцолсон бодит шалтгаангүй ч гэсэн сурталчлан таниулах явдал байдаг. Олон талт, эсрэг тэсрэг үзэл бодлыг уралдуулах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, дүн шинжилгээ хийх нь үнэн байдлыг тодруулах, асуудлын хамгийн шилдэг шийдлийг олохын тулд олон талаас нь харьцуулан дүгнэхэд олон түмэнд тустай байдаг. Эл үүрэг нь ялангуяа сонгогчдод нэр дэвшигчидтэй биечлэн уулзаж, тэдэнтэй ярилцах боломж олгодог, Америкад болон Монголд энэ жил болох гэж буй сонгуулийн кампанит ажлын үеэр онцгой чухал байдаг.

Мөн түүнчлэн хэвлэл нь засгийн газар болон бусад нийгмийн хүчирхэг институуцуудын үйл ажиллагаанд хяналт тавих хоточ нохойн үүрэг, хариуцлага хүлээдгийг 1993 оноос хойш НҮБ-ын санаачлагаар тэмдэглэж ирсэн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр бидэнд сануулдаг. Тиймээс хараат бус, бодит байх стандартыг бүрэн бус ч гэсэн даган мөрдөж байдаг чөлөөт хэвлэл засгийн газар буюу манай удирдлагууд юу хийсэн, юу хийх гэж байгаа талаар бодитой мэдээлж байдаг. Ингэснээр чөлөөт хэвлэл хийсэн үйлдэл, гаргасан шийдвэр, олсон ололт амжилт, гаргасан алдаа дутагдлынхаа төлөөх засгийн газрын хариуцлагыг өндөржүүлж, ил тод байдлыг нь дээшлүүлэхэд амин чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэвлэл нь нээлттэй захидал, эрэн сурвалжлах мэдээллээрээ дамжуулан олон нийтийн хэлэлцүүлэгт илүү идэвхитэй оролцож боломжтой хийгээд олон түмэн захидал, нийтлэл, Интернеттийн мэдээллэр дамжуулан өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх индэр нь болж байдаг. Монголын хэвлэлүүд хээль хахуулийн болон эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэгт холбогдсон хувь хүмүүс, байгууллагуудын үйлдлийг илчилж ил гарган тавьснаар ардчилал, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж чадах юм.

Хэвлэлийн эрх чөлөөг дэлхий дахинаа хөхүүлэн дэмжих талаар АНУ Монгол Улстай хоёр талын хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ олон хэлбэрээр олон талт үйл ажиллагаа явуулдаг. АНУ нь НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудын хараат бус байдлыг дэмжих Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн санаачлагч нь хийгээд дөрөв дэх том донор орон юм.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Төрийн нууцын тухай хуулиар хамгаалагдсан мэдээллийн жагсаалтыг нарийвчлан гаргах талаархи Глоб Интернэшнл ТББ-ын идэвхи зүтгэлд Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яам дэмжлэг үзүүлснээрээ бахархаж байдаг юм. Эдгээр алхмууд нь эдийн засгийнхаа хөгжлийг орчин үеийн түвшинд хүргэх гэсэн Монгол Улсын хүсэл эрмэлзэлд туйлын чухал юм. Учир нь мэдээллийн зах зээлгүйгээр үр бүтээлтэй ажиллах боломжгүй буюу зөвхөн мэдээллийг гартаа атгаж буй цөөн тооны хүмүүсийн эрх ашигт үйлчлэх болдог. Мөн түүнчлэн мэдээллийн эх сурвалжаа илрүүлэх талаар дарамт шахалт үзүүлэх болон гүжирдлэгийн хэргийг иргэний болон эрүүгийн шүүхээр шийдвэрлэх явдлаас сэтгүүлчдийг хамгаалахад чиглэсэн Глоб Интернэшнл ТББ-ын үйл ажиллагааг АНУ-ын Элчин сайдын яам дэмждэг. Эдгээр өөрчлөлтүүдийг хийснээр хэвлэлийн эрх чөлөө Монголын ардчилалд чухал хувь нэмэр оруулах юм. Гүтгэлгийн хэргийг иргэний шүүхээр шүүн шийдвэрлэх дэлхийн стандартад нийцсэн өөрчлөлтүүдийг өөрийн орны хууль тогтоомжуудад хийхийг Монгол Улсын Засгийн газарт АНУ-ын Элчин сайдын яам уриалсаар байна.

Дэлхий дахинд эрх чөлөөг дэмжих зорилгоор Элианор Рузвельтийн 1941 онд үүсгэн байгуулсан Эрх чөлөөний ордон ТББ саяхан сэтгүүлчдийн эрх чөлөөнд халдах, тэднийг дарамтлах явдал ихсэж байгаа, Төрийн нууцын тухай хуулиар төрийн мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байдаг, сэтгүүлчдийн эсрэг гүтгэлгийн асуудлаар эрүүгийн болон иргэний хэрэг үүсгэдэг явдал, мэдээллийн нууцлаг эх сурвалжаа илчлэх талаар сэтгүүлчдэд дарамт шахалт үзүүлэх явдал, болон өөрийгөө цагдан хянах түвшин хэр зэрэг байгаа зэргийг харгалзан Монголын хэвлэл мэдээллийн байгууллагыг “хагас эрх чөлөөт” хэмээн тодорхойлжээ.

Аливаа ардчилсан нийгэмд хэвлэл хичнээн чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулах таатай боломжийг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр бидэнд олгож байна. Хараат бус хэвлэл мэдээлэл хүмүүсийг хүчирхэгжүүлж, хээл хахуулийг илчилж, ил тод байдлыг хөхүүлэн дэмжиж, улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг. Үзэл бодлоо харилцан чөлөөтэй солилцох нь засгийн газрын хариуцлагыг өндөржүүлээд зогсохгүй олон нийт түүний дотор нийгмээс гадуурхагдсан хүмүүсийн үзэл бодлыг илэрхийлж байдаг. Ийм эрх чөлөөгүйгээр нийгэм бүхэлдээ хямралд ордог. АНУ Монгол Улсын гуравдагч хөршийн хувьд та бүхнийг мөрөөдөл, хүсэл зорилгоо биелүүлээсэй хэмээн хүсдэг. Ингэхийн тулд Монгол Улс хараат бус, шударга, хариуцлагатай хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх шаардлагатай ба ийм ч байх ёстой. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл илүү сайн ажиллаж чадах ба, үүнийг ч Монголын ард түмэн хүсэн хүлээж байна.